



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 131

Чингис хот

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 20 дугаар хуралдааны 23 тоот тогтоолын 3-р хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингис хотын Навааннэрэн, Тээвэрчид, Пунцаг, Тэмүүжингийн гудамжинд 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн явган хүний замын ажлын тоо хэмжээнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Лхагвабаатар- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Э.Золбаяр - Барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд: А.Боргил-Хэрлэн сумын Засаг даргын орлогч
Э.Мөнхбат- "Өндөрхаан хот тохижилтын газар"-ын дарга
Т.Бариашир - "Уран тод цэг" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Э.Батжаргал - "Уран тод цэг" ХХК-ийн инженер
Б.Од-Эрдэнэ - "Харгуй" ТӨХК-ийн ерөнхий Инженер
Ю.Цогхүү- "Хан хэнтий зам" ХХК-ийн захирал
Зөвшилцсөнөөр: Э.Элбэг-Эрдэнэ- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хяналтын инженер

2. Чингис хотын Навааннэрэн, Тээвэрчид, Пунцаг, Тэмүүжингийн гудамжинд 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн явган хүний замын ажлын тоо хэмжээнд хяналт шалгалтыг чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР